

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/46/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 51-261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аккаунт траст аудит ХХК-ийн захирал: П.Наранцэцэг
Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	11
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	11
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/636
танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын далайн захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Монгол улсын далайн захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,402.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Бодит нөхцөл байдалдаа үндэслэн орлогыг төлөвлөөгүйгээс тайлант онд 5,486.8 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс 4,652.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 834.7 сая төгрөгөөр тасарсан;
- Санхүүгийн тайлан дахь өмчийн дүн нь дүрмийн сангийн хөрөнгөөс 26.1 сая төгрөгөөр зөрүүтэй ;
- Авлагын дансанд найдваргүй болох эрсдэлтэй 27 гадаадын харилцагчтай холбоотой 117.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3, 71 дүгээр зүйлийн 8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үүрэг ба хариуцлага”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Архангай аймгийн Өгий нуурын эрэгт усан замын тээврийн “Хяналтын пост” байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж 2024 онд цахилгааны шугам, дэд өртөө байгуулж, усан замын хөвдөг зогсоол суурилуулж, 2025 онд гүний худаг гаргаж, гадна хашаа болон хяналтын байрыг барьж, тусгай зориулалтын завиар ханган “Хяналтын пост”-ыг ашиглалтад оруулсан байна. 2025 онд дээрх ажлын санхүүжилтэд 188.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд нийт 491,445 тонн даац бүхий 30 гаруй орны эзэмшлийн 241 хөлөг онгоц идэвхтэй бүртгэлд хамрагдан Монгол Улсын төрийн далбааг мандуулан их далайд аялж байна. Тайлант онд эдгээр хөлөг онгоцнуудаас 26 хөлөг онгоц дээр Далбааны эзэн улсын хяналт шалгалт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Бүгд найрамдах Солонгос Улсын далайн тээврийн компанитай хамтран далайн тээвэр хийх хуулийн этгээд байгуулах тухай 180 дугаар тогтоолын дагуу Монгол улсын далайн захиргаа, Бүгд найрамдах солонгос улсын “Саммок шиппинг” ХХК-ийн хороонд далайн тээврийн хамтарсан компани байгуулах гэрээ байгуулж, Сөүл хотод 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Mongol Sammok Logistics Co.,Ltd байгуулсан байна. Гэрээний дагуу оруулсан нийт 100,000.00 ам.доллар буюу тухайн үеийн ханшаар 190.2 сая төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалтаас үр өгөөж хүртээгүй, эрсдэлд орсон байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол улсын далайн захиргаа нь Монгол Улсын далайн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх, хөлөг онгоцны бүртгэлийг чанаржуулах, далайн тээврийн бодлого, хөгжлийн чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөн олон талын мэдээлэл солилцох боломж нээх чиглэлээр дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын Чойр хуурай боомт байгуулах тухай 2025 оны 234 дүгээр тогтоолын хүрээнд Нэгдсэн үндэсний байгууллагын Ази, Номхон далайн нийгэм эдийн засгийн комиссын ажлын хэсгийн VI хуралдаанд Монгол улсын далайн захиргааны төлөөлөл оролцож “Чойр” байршлыг Монгол Улсын хуурай боомтын жагсаалтад албан ёсоор оруулах тухай нэмэлт өөрчлөлтийн төслийг батлуулсан байна. Ийнхүү Монгол Улс нийт 9 хуурай боомттой байхаар олон улсын хэмжээнд баталгаажуулсан.
- Монгол улсын далайн захиргаа болон Бүгд Найрамдах Солонгос Улсын хөлөг онгоц эзэмшигчдийн холбоо хооронд 2025 оны 06 дугаар сард далайн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.
- Олон улсын далайн байгууллагын Ассамблейн 34 дүгээр чуулга уулзалтын хүрээнд Бүгд Найрамдах Панам Улс, Бүгд Найрамдах Либерти Улстай далайн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр уулзалт, хэлэлцээр зохион байгуулсан.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,651,412,975.62	4,784,678,165.45
1.1.2	Дансны авлага	12,258,009.80	479,000.09
1.1.4	Бусад авлага	572,603,248.34	521,711,859.83
1.1.6	Бараа материал	91,392,029.99	91,690,531.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	13,550,000.00	33,550,000.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,341,216,263.75	5,432,109,557.06
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,642,057,838.10	1,775,485,191.03
1.2.2	Биет бус хөрөнгө	25,837,007.51	24,151,573.95
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	190,192,000.00	190,192,000.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,858,086,845.61	1,989,828,764.98
1.3	НИЙТ ХӨРӨНГӨ	7,199,303,109.36	7,421,938,322.04
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	37,620,712.65	37,404,223.60
2.1.1.2	Цалингийн өглөг	807,540.21	807,540.21
2.1.1.3	Татварын өр	41,503,469.21	1,692,737.61
2.1.1.4	НДШ-ийн өглөг	48,355,454.86	
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	128,287,176.93	39,904,501.42
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	128,287,176.93	39,904,501.42
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	244,784,600.24	244,784,600.24
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	62,460.00	62,460.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	6,826,168,872.19	7,137,186,760.38
2.3.20	Эздийн өмчийн дүн	7,071,015,932.43	7,382,033,820.62
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	7,199,303,109.36	7,421,938,322.04

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,723,063,508.63	4,175,563,430.02
3	Борлуулалтын өртөг	-	-
4	Нийт ашиг (алдагдал)	3,723,063,508.63	4,175,563,430.02
6	Хүүгийн орлого	460,008,770.69	436,950,591.43
9	Бусад орлого	88,561,950.43	39,567,109.19
11	Ерөнхий ба удирдлагын зардал	5,375,524,243.13	4,146,505,696.76
12	Улсын төсвийн төв төрийн санд төвлөрүүлсэн	255,000,000.00	300,000,000.00
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,358,890,013.38)	205,575,433.88
20	Орлогын татварын зардал	2,420,561.28	42,950,487.73
21	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,361,310,574.66)	162,624,946.15
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,361,310,574.66)	162,624,946.15
24	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
25	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
26	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү/олз/	7,713,803.03	21,259,050.52
27	Бусад олз (гарз)	(21,296,196.77)	(12,621,832.28)
28	Орлогын нийт дүн	(1,374,892,968.40)	171,262,164.39

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	231,164,305.84	62,460.00	8,201,061,840.59	8,432,288,606.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,620,294.40	-	-	13,620,294.40
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,784,600.24	62,460.00	8,201,061,840.59	8,445,908,900.83
Тайлангийн үеийн үр дүн	-	-	(1,374,892,968.40)	(1,374,892,968.40)
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	244,784,600.24	62,460.00	6,826,168,872.19	7,071,015,932.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	139,755,723.80	139,755,723.80
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,784,600.24	62,460.00	6,965,924,595.99	7,210,771,656.23
Тайлангийн үеийн үр дүн	-	-	171,262,164.39	171,262,164.39
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	244,784,600.24	62,460.00	7,137,186,760.38	7,382,033,820.62

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,571,815,729.86	4,715,037,034.33
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,990,419,406.92	4,244,412,706.39
1.1.2	Хүүгийн орлого	447,940,050.20	436,950,591.43
1.1.6	Бусад мөнгөн орлого	133,456,272.74	33,673,736.51
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	5,165,669,802.73	4,386,123,406.80
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,367,518,708.57	2,035,762,696.29
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	319,035,302.09	243,614,404.26
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	139,419,199.17	138,796,411.63
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	253,110,400.00	400,471,260.30
	Эд хогшил, урсгал засварын зардал	117,079,073.00	136,918,450.00
	Томилолт, зочны зардал	379,503,878.25	475,289,192.10
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,120,106,317.04	362,742,309.36
	Бараа үйлчилгээний бусад зардал	289,266,881.77	66,014,479.80
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	292,767,191.47	139,277,003.06
213202	Бусад урсгал шилжүүлэг	632,862,851.37	87,237,200.00
213204	Төвлөрүүлэх шилжүүлэг	255,000,000.00	300,000,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(593,854,072.87)	328,913,627.53
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	1,155,208.23
2.1.7	Валютын ханшийн зөрүү		1,155,208.23
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	819,913,523.35	188,332,012.05
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	819,913,523.35	188,332,012.05
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(819,913,523.35)	(187,176,803.82)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	(14,907,882.46)	(8,471,633.88)
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,428,675,478.68)	133,265,189.83
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,080,088,454.30	4,651,412,975.62
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,651,412,975.62	4,784,678,165.45

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			4,271,634.2	5,486,800.0	4,652,081.1	380,446.9	108.9	(834,718.9)	84.8
1	Хөлөг онгоцны бүртгэлийн орлого	м.төг	3,723,063.5	4,981,800.0	4,175,563.4	452,499.9	112.2	(806,236.6)	83.8
	Хүүгийн орлого	м.төг	460,008.8	500,000.0	436,950.6	(23,058.2)	95.0	(63,049.4)	87.4
	Бусад орлого	м.төг	88,562.0	5,000.0	39,567.1	(48,994.8)	44.7	34,567.1	791.3
2	Нийт орлого	м.төг	4,271,634.2	5,486,800.0	4,652,081.1	380,446.9	108.9	(834,718.9)	84.8
3	Нийт зардал	м.төг	5,630,524.2	5,109,820.8	4,446,505.7	(1,184,018.5)	79.0	(663,315.1)	87.0
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	5,377,944.8	4,809,820.8	4,146,505.7	(1,231,439.1)	77.1	(663,315.1)	86.2
4	Татварын өмнөх ашиг	м.төг	(1,358,890.0)	376,979.2	205,575.4	1,564,465.4	(15.1)	(171,403.8)	54.5
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(1,374,893.0)	-	171,262.2	1,546,155.1	(12.5)	171,262.2	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	м.төг	7,713.8	-	21,259.1	-	-	-	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	м.төг	21,296.2	-	12,621.8	-	-	-	-
	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	413,712.2	492,881.9	497,917.9	84,205.7	120.4	5,035.9	101.0
6	а/ Орлогын татварт	м.төг	2,420.6	2,500.0	42,950.5	40,529.9	1,774.4	40,450.5	1,718.0
	в/ НДШ	м.төг	319,035.3	271,434.4	243,614.4	(75,420.9)	76.4	(27,820.0)	89.8
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	91,669.7	217,147.5	209,508.9	117,839.1	228.5	(7,638.7)	96.5
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	586.6	1,800.0	1,844.1	1,257.5	314.4	44.1	102.5
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	39.0	43.0	43.0	4.0	110.3	-	100.0
9	Нийт цалингийн сан	м.төг	1,367,518.7	2,171,475.4	2,035,762.7	668,244.0	148.9	(135,712.7)	93.8
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	35,064.6	50,499.4	47,343.3	12,278.7	135.0	(3,156.1)	93.8
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.8	1.1	1.0	0.3	137.9	(0.0)	97.4
12	Хөрөнгө оруулалт	м.төг	819,913.5	251,707.0	188,332.0	(631,581.5)	23.0	(63,375.0)	74.8
13	Нийт авлага	м.төг	584,861.3	-	522,190.9	(62,670.4)	89.3	522,190.9	
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	
	Нийт өглөг	м.төг	128,287.2	-	39,904.5	(88,382.7)	31.1	39,904.5	
14	Богино хугацаат өр төлбөр	м.төг	127,479.6	-	39,097.0	(88,382.7)	30.7	39,097.0	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг							

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зам тээврийн сайдын 2025 оны А/02 тоот тушаалаар баталсан Далайн захиргааны дүрэмд тус захиргааны чиг үүргийг “Далайн захиргаа нь Монгол Улсын Их хурал, Засгийн газрын бодлого, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанаас олсон орлогоос далайн болон усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан орлого, зарлагын төлөвлөгөөний дагуу санхүүжиж, улсын төсөвт орлого төвлөрүүлж, далайн болон усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллах бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж, тайлагнана.” гэж тодорхойлсон байна.

Тус захиргаа нь хөлөг онгоц болон усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын үйл ажиллагаа явуулах, далайн болон усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, салбарын боловсон хүчнийг бэлтгэх, далайн тээвэр, боомт ашиглахтай холбогдох эрх үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсын далайн захиргаа нь тайлант онд дараах 10 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Далайн болон усан замын тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах;
- Далайн болон усан замын тээврийн үйл ажиллагааг чанаржуулах;
- “Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгагдсан байршлуудад хуурай боомтыг үе шаттай байгуулах;
- Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, олон улсын хурал санаачлан зохион байгуулах;
- Монгол улсын далайн захиргааны хэвийн үйл ажиллагааг хангах;
- Байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах;
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх;
- Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гарган, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;
- Салбарын хүний нөөцийг бэлтгэж, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах;
- Далайн болон усан замын тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн зөвлөгөөгөөр ханган дэмжлэг үзүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Далай ашиглах тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Далайд гарцгүй улсуудын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрсөн Барселоны 1921 оны тунхаглал, Далайд гарцгүй орны транзит худалдааны тухай конвенц, тэдгээрийг дагалдан гарсан холбогдох дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монгол улсын далайн захиргааны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Монгол улсын далайн захиргааны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол улсын далайн захиргааны даргын 2024 оны 01/95 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 220.1 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,651,413.0	4,784,678.1	133,265.1
Авлага	584,861.3	522,190.9	(62,670.4)
Урьдчилж төлсөн зардал	13,550.0	33,550.0	20,000.0
Бараа материал	91,392.0	91,690.5	298.5
Үндсэн хөрөнгө	1,667,894.8	1,799,636.8	131,742.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	190,192.0	190,192.0	-
Нийт хөрөнгө	7,199,303.1	7,421,938.3	222,635.2
Өр төлбөр	128,287.2	39,904.5	(88,382.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,071,015.9	7,382,033.8	311,017.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,199,303.1	7,421,938.3	222,635.2

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,784.7 сая төгрөг болж 133.3 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст хөлөг онгоцны бүртгэлийн орлого төвлөрсөн;
- Авлага дансны үлдэгдэл 522.2 сая төгрөг болж 62.7 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсдаас авах авлага 11.8 сая төгрөгөөр, байгууллага хоорондын авлага 0.2 сая төгрөгөөр, далбаа ашиглуулсны авлага 27.2 сая төгрөгөөр тус тус буурсан;
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 33.5 сая төгрөг болж 20.0 сая төгрөгөөр өссөн нь оффисын түрээсийн барьцаа төлбөр 20.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,799.6 сая төгрөг болж 131.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 200.3 сая төгрөгөөр Архангай аймгийн Өгий нуурын болон Хөвсгөлийн хяналтын постын хөрөнгө, 137.7 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 52.2 сая төгрөгөөр тавилга эд хогшил тус тус худалдан авсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 39.9 сая төгрөг болж 88.4 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг 0.2 мянган төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварын өглөг 39.8 сая төгрөгөөр буурсан;
- Засгийн газрын хувь оролцооны дүн 7,382.0 сая төгрөг болж 311.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол улсын далайн захиргаа нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Зам тээврийн сайдын 2025 оны А/14 тоот тушаалаар Монгол улсын далайн захиргааны 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний нийт орлогыг 5,486.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 5,109.8 сая төгрөгөөр, 377.0 сая төгрөгийн ашигтай ажиллагааар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 251.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 4,652.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,446.5 сая төгрөгийн зардал гарган, 205.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,652.1 сая төгрөг болж, өмнөх оны гүйцэтгэлээс 380.4 сая төгрөг буюу 8.9 хувиар өссөн, төлөвлөснөөс 834.7 сая төгрөг буюу 15.2 хувиар тасарсан байна. Хөлөг онгоцны бүртгэлийн үнийг 15 хувиар нэмэгдүүлсэн нь тайлант оны орлогын өсөлтөд нөлөө үзүүлсэн байна.

Монгол улс нь 2003 онд Монгол Улс Токио MOU (Токиогийн харилцан ойлголцлын санамж бичиг буюу Ази-Номхон далайн бүс нутгийн боомтын хяналтын байгууллага)-ын “Хар жагсаалт”-д орсон байна. Хар жагсаалтаас гаргахын тулд шаардлага хангахгүй хөлөг онгоцнуудыг бүртгэлээс хассанаар хөлөг онгоцны тоо буурсан нь орлогын төлөвлөгөө тасрахад гол нөлөө үзүүлсэн байна. Хөлөг онгоцны бүртгэл, хяналт дээр онцгойлон анхаарч стратеги, бодлогыг хэрэгжүүлснээр сүүлийн жилүүдэд саатуулагдсан хөлөг онгоцны тоо буурсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,446.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,184.0 сая төгрөг буюу 21.0 хувиар буурч, төлөвлөснөөс 663.3 сая төгрөг буюу 13.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсвөөс цалин хөлсний зардлыг 135.7 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 27.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 28.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 73.1 сая төгрөгөөр, томилолт, зочны

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

зардлыг 68.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 161.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 141.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь зардал буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 188.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 205.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1,564.5 сая төгрөгөөр өссөн, төлөвлөснөөс 171.3 сая төгрөг буюу 45.5 хувиар дутуу байна. Энэ нь бодит нөхцөл байдалтай уялдуулан орлогыг төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө тасарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд төлөвлөгөөний дагуу улсын төсвийн төв төрийн санд 300.0 сая төгрөг төвлөрүүлж, нийт зардлын дүнд оруулан тайлагнасан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа.

Үүнд:

- Зам тээврийн сайдын 2025 оны А/02 дугаар тушаалаар Монгол улсын далайн захиргааны орон тооны дээд хязгаарыг 39, зохион байгуулалтын бүтцийг 3 хэлтэс, 2 албатай байхаар баталсан байна. Тайлант онд орон тоонд өөрчлөлт ороогүй байна.
- Гадаад зочин хүлээн авах 16 арга хэмжээнд 35.0 сая төгрөгийн зардлын төсөв батлагдсанаас 32.9 сая төгрөг зарцуулж, 2.1 сая төгрөг зарцуулаагүй үлдсэн, 26 удаагийн гадаад томилолтод 344.5 сая төгрөг төлөвлөснөөс 31 удаагийн томилолтод 340.6 сая төгрөг зарцуулж, 3.9 сая төгрөг хэмнэсэн байна.
- Тайлант онд байгууллагын ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 9 сургалтад 94.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 11 сургалтад ажилтнуудыг хамруулан 16.1 сая төгрөг зарцуулсан байна. Төлөвлөсөн зарим гадаад сургалт цуцлагдсанаас төсөв зарцуулаагүй үлдсэн байна.
Мөн усан замын ахлах болон улсын байцаагч нарын дунд усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулж 1.3 сая төгрөг зарцуулсан байна.
- Монгол улсын далайн захиргааны даргын 2024 оны А/171 тоот тушаалаар ажлын өдөрт хоолонд 35.0 мянган төгрөг, унаанд 5.0 мянган төгрөгийн хөнгөлөлт олгохоор баталсан байна. Тайлант онд нийт 318.6 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт ажилчдад олгосон байна.
- Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс болж ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 182/ШШ2022/02434 дүгээр шийдвэрээр 15.5 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 182/ШШ2024/00043 дугаар шийдвэрээр 30.0 сая төгрөг, нийт 45.5 сая төгрөгийн нөхөн олговор байгууллагаас олгосон зөрчилд өмнөх аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн байна.

Нөхөн олговрыг барагдуулах чиглэлээр МУДЗ дараах ажлыг хийсэн байна. Үүнд:

- Монгол улсын далайн захиргаа нь 15.5 сая төгрөгийн нөхөн олговрыг шүүхэд хандан нэхэмжилж, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 191/ШЗ2025/13879 дугаар захирамжаар Иргэний хэрэг үүсгэсэн

байна. Хариуцагчийн оршин суух хаяг тодорхойгүй байгаа тул СБД-ийн цагдаагийн газар эрэн сурвалжилж байна.

- Мөн 30.0 төгрөгийн нөхөн олговрыг шүүхэд хандан нэхэмжилсэн боловч, шүүх төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд биш гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тул Зам, тээврийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/270 дугаар албан бичгээр уг асуудлыг шийдвэрлүүлэхээр хандсан байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нийт 766.9 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, МУДЗ-ны даргын 2025.01.21-ний А/08 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар 300.0 сая төгрөгийн 2, харьцуулалтын аргаар 311.4 сая төгрөгийн 7, шууд худалдан авалтаар 155.5 сая төгрөгийн 11 бараа ажил үйлчилгээг тус тус худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар 129.2 сая төгрөгийн 1, харьцуулалтын аргаар 135.3 сая төгрөгийн 3, шууд худалдан авалтаар 121.1 сая төгрөгийн 11, нийт 385.6 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг тус тус худалдан авсан байна.

Хөшигийн хөндийд хуурай боомт байгуулах нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа, Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэгтгэн зохион байгуулах, далайн боомт хүргэх нөхцөл боломжийг тодорхойлох 100.0 сая төгрөгийн судалгааг дотоод нөөц бололцоогоо дайчлан, өөрийн ажилчдаар гүйцэтгүүлж зардал хэмнэн, 240.0 сая төгрөгийн 3 бараа ажил үйлчилгээний худалдан авалтыг дараа онд хийхээр хойшлуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол улсын далайн захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Монгол улсын далайн захиргаа, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Монгол улсын далайн захиргааны үйл ажиллагааг сайжруулах хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх, урт хугацаат хөрөнгө оруулалтын талаар холбогдох арга хэмжээ авах, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэх тогтоох талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аккаунт траст ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, захирал П.Наранцэцэг нар, дараагийн шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол улсын далайн захиргаа 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/44 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 5,654.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 56.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласнаар цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 135.7 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 27.8 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 73.1 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 68.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 141.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 161.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 338.6 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18 гүйлгээ, орлогын 2, нийт 338.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь “Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, илрүүлсэн 203.9 сая төгрөгийн 4 алдааг залруулах саналыг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар илэрсэн алдааг залруулж шийдвэрлэсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 6,812.3 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 6 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгснийг 69.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	3	49,006.6	3	49,006.60	100.0
2	Албан шаардлага	6	6,733,342.9	3	582,508.0	66.4
3	Зөвлөмж	4	30,000.0	3	30,000.0	77.5
	Нийт дүн	13	6,812,349.5	7	661,514.6	69.0

Өмнөх аудитаар өгсөн хэрэгжээгүй дараах шийдвэрүүдэд 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 3 асуудлыг дээд шатны төсөв захирагчийн анхаарал хандуулах асуудалд шилжүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэх, компанийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;
- Шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас олгосон нөхөн олговрыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авах 30.0 сая төгрөгийн зөвлөмж, 15.4 сая төгрөгийн албан шаардлагыг шийдвэрлүүлэхээр дээд шатны төсөв захирагчийн анхаарал хандуулах асуудалд шилжүүлэх;
- Байгууллагын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох албан шаардлагыг шийдвэрлүүлэхээр дээд шатны төсөв захирагчийн анхаарал хандуулах асуудалд шилжүүлэх;
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг таслан зогсоох асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг дээд шатны төсөв захирагчийн болон дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс болж ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд олгосон нөхөн олговортой холбогдох нийт 45.5 сая төгрөгийн зөрчлийг барагдуулах арга хэмжээ авах.
- Тус байгууллагын хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрийг улсын бүртгэлийн гэрчилгээнд "төрийн байгууллага, албан газар" гэж тодорхойлсон. Зам тээврийн сайд тус байгууллагын орлого, зарлагын төлөвлөгөөг баталдаг, байгууллага нь өөрийн орлогоор санхүүжиж, улсын төсөвт жил бүр орлого төвлөрүүлдэг байна. Байгууллагын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох талаар өмнөх аудитаас өгсөн албан шаардлагын дагуу дээд шатны төсөв захирагчид хандсан боловч тус асуудал шийдвэрлэгдээгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 86.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Цалингийн зөрүү, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, томилолтын зөрүү, Улсын тэмдэгтийн хураамжийн буцаалт зэрэг тооцооны 39.2 сая төгрөгийн зөрүүг бусад орлогоор тайлагнасан.
- Санхүүгийн тайлангийн машин тоног төхөөрөмжийн дүн нь үндсэн хөрөнгийн тодруулгын дүнгээс 1.9 сая төгрөгөөр дутуу, биет бус хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн 2.3 сая төгрөгийг тодруулгад тайлагнаагүй.
- Хадгаламжийн хүүгийн орлогоос татварын 42.9 сая төгрөгийг хасч дутуу тайлагнасан байна.

Эдгээр алдаа нь НББОУС1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцэхгүй, “ангилал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Аудитаар нийт 1,402.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд, 952.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 450.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,402.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,346.4 сая төгрөгөөр их тул хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Авлагатай холбоотой

Авлагын дансанд бүртгэлтэй 2-4 жилийн насжилттай 27 харилцагчаас авах 117.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өндөр насжилттай авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой

Бодит нөхцөл байдалдаа үндэслэн орлогыг төлөвлөөгүйгээс тайлант онд 5,486.8 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс 4,652.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 834.7 сая төгрөгөөр тасарсан, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эздийн өмчтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайлан дахь өмчийн дүн нь дүрмийн сангийн хөрөнгөөс 26.1 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах,” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дүрмийн сангийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, зөрүүг арилгах арга хэмжээ авах.

2. Урт хугацаат хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Урт хугацаат хөрөнгө оруулалтад оруулсан 190.2 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож тайлагнаагүй байна. Тодруулбал, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Бүгд найрамдах Солонгос Улсын далайн тээврийн компанитай хамтран далайн тээвэр хийх хуулийн этгээд байгуулах 180 дугаар тогтоолын дагуу Монгол улсын далайн захиргаа, Бүгд Найрамдах Солонгос Улсын “Саммок шиппинг” ХХК-ийн хороонд далайн тээврийн хамтарсан компани байгуулах гэрээ байгуулж, Сөүл хотод 2015 оны 07дугаар сарын 08-ны өдөр Mongol Sammok Logistics Co.,Ltd-ийг байгуулсан байна. Гэрээний дагуу компанийн хувьцааг талууд 50:50 хувиар эзэмшиж, 100.1 сая вон буюу 100,000.00 ам.долларын хөрөнгө оруулсан байна. Тус хамтарсан компани нь байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагаа явуулаагүй, хөрөнгө оруулалтад оруулсан хөрөнгө дундын дансанд байршиж байгаа гэх боловч нотлох боломжгүй, тус хөрөнгө оруулалтаас үр өгөөж хүртээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1-т “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;”, 67 дугаар зүйлийн 1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах,” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Урт хугацаат хөрөнгө оруулалтын талаар холбогдох арга хэмжээг авч, хөрөнгө оруулалтын үр өгөөж, ханшийн тэгшитгэлийг тооцож бүртгэх.

3. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 424.8 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цалингийн зөрүү, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, томилолтын зөрүү, Улсын тэмдэгтийн хураамжийн буцаалт зэрэг тооцооны 39.2 сая төгрөгийн зөрүүг бусад орлогоор тайлагнасан.	1	39,205.7	-	-	1	39,205.7	1	39,205.7	-	-	-	-
2	Санхүүгийн тайлангийн машин тоног төхөөрөмжийн дүн нь үндсэн хөрөнгийн тодруулгын дүнгээс 1.9 сая төгрөгөөр дутуу, биет бус хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн 2.3 сая төгрөгийг тодруулгад тайлагнаагүй.	1	4,223.4	-	-	1	4,223.4	1	4,223.4	-	-	-	-
3	Хадгаламжийн хүүгийн орлогоос татварын 42.9 сая төгрөгийг хасч дутуу тайлагнасан байна.	1	42,944.5	-	-	1	42,944.5	1	42,944.5				
	Дүн	3	86,373.6	-	-	3	86,373.6	3	86,373.6	-	-	-	-

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлан дахь өмч нь дүрмийн сангийн хөрөнгөөс 26.1 сая төгрөгөөр зөрүүтэй	1	26,068.3	-	-	-	-	1	26,068.3	-	-	-	-
2	Урт хугацаат хөрөнгө оруулалтад оруулсан 190.2 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож тайлагнаагүй байна. Тодруулбал, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Бүгд найрамдах Солонгос Улсын далайн тээврийн компанитай хамтран далайн тээвэр хийх хуулийн этгээд байгуулах 180 дугаар тогтоолын дагуу Монгол улсын далайн захиргаа, Бүгд Найрамдах Солонгос Улсын “Саммок шиппинг” ХХК-ийн хороонд далайн тээврийн хамтарсан компани байгуулах гэрээ байгуулж, Сөүл хотод 2015 оны 07дугаар сарын 08-ны өдөр Mongol Sammok Logistics Co.,Ltd-ийг байгуулсан байна. Гэрээний дагуу компанийн хувьцааг талууд 50:50 хувиар эзэмшиж, 100.1 сая вон буюу 100,000.00 ам.долларын хөрөнгө оруулсан байна. Тус хамтарсан компани нь байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагаа явуулаагүй, хөрөнгө оруулалтад оруулсан хөрөнгө дундын дансанд байршиж байгаа гэх боловч нотлох боломжгүй, тус хөрөнгө оруулалтаас үр өгөөж хүртээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	

Монгол улсын далайн захиргааны 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

3	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглаж байгаа 424.8 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	424,829.6	-	-	-	-	1	424,829.6	-	-	-	-
4	Авлагын дансанд найдваргүй болох эрсдэлтэй 27 гадаадын харилцагчтай холбоотой 117.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна	1	117,247.5	-	-	1	117,247.5	-	-	-	-	-	-
5	Бодит нөхцөл байдалдаа үндэслэн орлогыг төлөвлөөгүйгээс тайлант онд 5,486.8 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс 4,652.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 834.7 сая төгрөгөөр тасарсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	834,718.9	-	-	1	834,718.9	-	-	-	-	-	-
	Дүн	5	1,402,864.3	-	-	2	951,966.4	3	450,897.9	-	-	-	-

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18 гүйлгээ, орлогын 2, нийт 338.6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	338,584.2			1	338,584.2		
	Дүн	1	338,584.2	-	-	1	338,584.2	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 758/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/46/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлагын дансанд бүртгэлтэй 2-4 жилийн насжилттай 27 харилцагчаас авах 117,247,469.00 /Нэг зуун арван долоон сая хоёр зуун дөчин долоон мянга дөрвөн зуун жаран есөн/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол улсын далайн захиргааны дарга /М.Өлзий/, ерөнхий нягтлан бодогч /М.Гантулга/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
П.НАРАНЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 759/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/46/НА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны орлогын төлөвлөгөөг 834,718,869.00 /Найман зуун гучин дөрвөн сая долоон зуун арван найман мянга найман зуун жаран есөн/ төгрөгөөр тасалсан, өмнөх аудитаар өгсөн зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэх, компанийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах зөвлөмж хэрэгжээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10. "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогыг бодитой төлөвлөөгүй, биелүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол улсын далайн захиргааны дарга /М.Өлзий/, ерөнхий нягтлан бодогч /М.Гантулга/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮГЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
П.НАРАНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 760/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/46/НА-СТА - ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18, орлогын 2, нийт 338,584,212.00 /Гурван зуун гучин найман сая таван зуун наян дөрвөн мянга хоёр зуун арван хоёр/ төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй, мөн Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол Улсын Далайн захиргааны ерөнхий нягтлан бодогч М.Гантулгад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Далайн захиргааны дарга /М.Өлзий/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
П.НАРАНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага талруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

АГА16007
9922.001411

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-41.Docx

1526180990